

Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. МХҮХ нь Монгол Улсын хууль зүйн яаманд бүртгэлтэй, гишүүдээ үйлчилдэг ашгийн бус, төрийн бус байгууллага байна.
- 1.2. МХҮХ нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.3. МХҮХ нь Дэлхийн Хараагүйчүүдийн Холбооны үндэсний гишүүн байгууллага байна.
- 1.4. Монголын хараагүйчүүдийн Үндэсний Холбоо нь өөрийн билэгдэл тэмдэг, түүх уламжлал, тамга тэмдэгтэй байна.
- 1.5. МХҮХ нь тус холбооны төв удирдлага байрлаж буй газарт байрлана.

Хоёр. Зорилго

- 2.1 МХҮХ-ны зорилго нь хараагүй иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хүний хөгжлийг дэмжих, нийгмийн харилцаанд бусдын адил тэгш эрхтэй оролцох боломжийг бүрдүүлэхэд оршино.

Гурав. Үйл ажиллагаа

- 3.1 Хараагүй иргэний нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлт, соёл урлаг, спортын үйл ажиллагааг сайжруулах,
- 3.2 Хараагүй иргэдийн асуудлаар санал боловсруулан төр, захиргааны байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих,
- 3.3 Хараагүй хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдний хөгжлийг дэмжсэн олон талт үйл ажиллагааг явуулах, энэ чиглэлээр бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах,
- 3.4 Дэлхийн Хараагүйчүүдийн Холбоо, бүс нутгийн хараагүйчүүдийн холбоо болон бусад олон улсын хараагүйчүүдийн байгууллагуудын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож хамтран ажиллах
- 3.5 Хараагүй иргэдэд зориулсан тусгай хэрэглээний техник хэрэгсэл, мэдээллийн технологи нэвтрүүлэх
- 3.6 Хараагүй иргэдийн талаарх төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх.
- 3.7 МХҮХ-ны зорилгод нийцсэн бусад хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжих

Дөрөв. МХҮХ-ны байгуулалтын зарчим

- 4.1 МХҮХ нь хамтарсан удирдлагын ардчилсан зарчимд тулгуурлан ажиллана.
- 4.2 МХҮХ-ны бүх шатны байгууллагуудыг илээр буюу нууцаар санал хурааж олонхын саналаар байгуулна.
- 4.3 Аливаа асуудлыг хууль, тогтоомж болон дүрмийг үндэслэн олонхын саналаар шийдвэрлэх боловч цөөнхийн саналыг хүндэтгэн үзнэ.

Тав. Их Хурал, түүний эрх үүрэг

- 5.1 МХҮХ-ны удирдах дээд байгууллага нь их хурал байна.
- 5.2 Их хурлыг 4 жил тутамд нэг удаа хуралдуулна.
- 5.3 Ээлжит бус их хурлыг Холбооны удирдах зөвлөлийн гишүүдийн дөрөвний гурав 4/3, нийт гишүүдийн гуравны хоёроос 3/2 –оос доошгүй хувийн саналаар зарлан хуралдуулна.
- 5.4 Их хурал нь аймаг, нийслэлийн бага хурлуудаас сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.
- 5.5 Их хурлын төлөөлөгчдийн ирц дийлэнх олонхи буюу 66.6%-с дээш байвал хурлыг хүчинтэйд тооцно.

- 5.6 МХҮХ-ны хандивлагч гишүүн их хуралд ажиглагчаар таслах эрхгүй оролцож болно.
- 5.7 Их хурал нь тус холбооны дүрэм, түүнд оруулах нэмэлт өөрчлөлт, удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгнө.
- 5.8 Их хурал нь МХҮХ-ны Удирдах зөвлөл, тус холбооны хяналтын зөвлөлийг сонгож батална.

Зургаа. Удирдах зөвлөл, түүний эрх, үүрэг

- 6.1 МХҮХ-ны удирдах зөвлөл 11 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 6.2. Удирдах зөвлөлийн дарга нь холбооны ерөнхийлөгч байна.
- 6.3. Шинээр сонгогдсон Удирдах зөвлөлийн анхны хурлыг удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос насаар хамгийн ахмад гишүүн удирдана.
- 6.4 Удирдах зөвлөлийн хурлыг жилд 4-өөс доошгүй удаа хуралдуулна.
- 6.5 Удирдах зөвлөлийн гишүүдийн ирц олонхи буюу 51.0%-с дээш байвал хурлыг хүчинтэйд тооцно.
- 6.6 Удирдах зөвлөл нь Холбооны ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, ерөнхий нарийн бичгийн даргыг сонгож батална, өөрчилнө.
- 6.7 Удирдах зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар буюу Холбооны нэр хүндэд харшлах ёс зүйн алдаа гаргасан тохиолдолд чөлөөлөн нөхөн сонгоно.
- 6.8 Удирдах зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгохдоо их хурлаас удирдах зөвлөлд нэр дэвшсэн гишүүдээс саналын тооны дарааллаар нөхөн сонгож батлана.
- 6.9 МХҮХ-ны үйл ажиллагааны ойрын ба хэтийн чиглэл, стратеги, бодлогыг тодорхойлно.
- 6.10 МХҮХ-ны жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг хэлэлцэж батлана.
- 6.11 Удирдах зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн даргын жилийн ажлын тайланг хэлэлцэж дүгнэнэ.
- 6.12. Гадаадын ба олон улсын байгууллагатай харилцах асуудлын чиглэлийг тогтооно.
- 6.13. МХҮХ-ны дэргэд ажиллах бүтцийн байгууллагуудын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 6.14. Удирдах зөвлөлийн бүрэн эрх нь дараагийн шинэ удирдах зөвлөлийн гишүүд сонгогдсон тухай их хурлын тогтоол гарснаар дуусгавар болно.

Долоо. МХҮХ-ны ерөнхийлөгч, түүний эрх, үүрэг

- 7.1 МХҮХ-ны ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, ерөнхий нарийн дарга нь удирдах зөвлөлийн гишүүн байна.
- 7.2 МХҮХ-ны ерөнхийлөгчийг дахин нэг удаа улируулан сонгож болно.
- 7.3 МХҮХ-ны ерөнхийлөгч нь холбоог гадаад дотоодод
- 7.4 төлөөлнө.
- 7.4 МХҮХ-ны ерөнхийлөгчийн эзгүйд дэд ерөнхийлөгч орлон түүний бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 7.5. МХҮХ-ны ерөнхийлөгч нь удирдах зөвлөлийн хурлыг удирдана.

Найм. Ерөнхий нарийн бичгийн даргын, түүний эрх үүрэг

- 8.1 МХҮХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга нь тус холбооны ерөнхий менежер байна.
- 8.2 МХҮХ-ны ерөнхий менежер нь тус холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион

байгуулна.

- 8.3 МХҮХ-ны ерөнхий менежер нь тус холбооны жилийн ажлын төлөвлөгөө төсвийг боловсруулж, батлуулах, төсөв хөрөнгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна.
- 8.4 МХҮХ-ны ерөнхий менежер нь Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавьж, бүртгэл тооцооны ажлыг байх шаардлагатай түвшинд хүргэж зохион байгуулна.
- 8.5 МХҮХ-ны ерөнхий менежер нь тус холбоог санхүүгийн эх үүсвэрээр хангах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 8.6 МХҮХ-ны ерөнхий менежер нь тус холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гаргаж, Удирдах зөвлөл, холбогдох бусад байгууллагад хүргүүлнэ.
- 8.7.1 МХҮХ-ны ерөнхий менежер нь тус холбоонд хөдөлмөрийн гэрээгээр шаардлагатай хүмүүсийг авч ажиллуулна, ажлаас чөлөөлнө.
- 8.8 МХҮХ-ны ерөнхий менежер нь Холбооны салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, ажлын тайланг нь гаргуулан авч дүгнэнэ.
- 8.9 МХҮХ-ны ерөнхий менежер нь Холбоог эрх хэмжээнийхээ хүрээнд бусдын өмнө төлөөлнө.

Ес. Хяналтын зөвлөл, түүний эрх үүрэг

- 9.1 Хяналтын Зөвлөлийг их хурлаас, салбарын хяналтын зөвлөлийг аймаг, хотын салбарын бага хурлаас 3-5 хүний бүрэлдэхүүнтэй сонгож байгуулна.
- 9.2 Хяналтын зөвлөлд МХҮХ-ны гишүүн бус иргэд сонгогдож болох бөгөөд хараагүй гишүүний төлөөлөл байна.
- 9.3 Хяналтын зөвлөл байгууллагын дүрмийн хэрэгжилт, санхүүгийн зарцуулалт, эд аж ахуйн бүртгэл, гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт, бичиг хэргийн хөтлөлт, эмх цэгц, эрэлт хүсэлт барагдуулалтанд хяналт тавьж шалгана.
- 9.4 Хяналтын зөвлөл нь ажлаа жилээр төлөвлөж, хийсэн ажлаа удирдах зөвлөлд танилцуулж их хуралд тайлагнана.

Арав. МХҮХ-ны салбар, зөвлөл

- 10.1 Нийгэмлэгийн салбар зөвлөл, хэсэг нь анхан шатны нэгж бөгөөд салбар зөвлөлийг аймаг, нийслэлд байгуулна.
- 10.2 Салбар зөвлөлийн удирдах дээд байгууллага нь бага хурал байна. Бага хурлыг 2 жилд нэг удаа хуралдуулна. Ээлжит бус бага хурлыг удирдах зөвлөлийн гишүүдийн дөрөвний гурав 4/3 нийт гишүүний гуравны хоёроос 3/2-оос доошгүй хувийн саналаар зарлан хуралдуулж болно.
- 10.3 Салбар зөвлөлийн бага хурлаас удирдах зөвлөлийг 5-7 гишүүний бүрэлдэхүүнтэй сонгох ба удирдах зөвлөлийн хурлаас салбар зөвлөлийн даргыг сонгоно.
- 10.4 Салбар зөвлөл нь холбооны удирдлагын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлнэ.

Арван нэг. МХҮХ-ны гишүүн

- 11.1 МХҮХ-ны гишүүн нь үндсэн ба хандивлагч гэсэн ангилалтай байна. МХҮХ-ны үндсэн гишүүн нь тус холбооны дүрмийг хүлээн зөвшөөрсөн, харааны бэрхшээлтэйн улмаас хөдөлмөрийн чадвараа 50 буюу түүнээс дээш хувиар алдсан 16 нас хүрсэн, Монгол улсын болон харъяалалгүй гадаадын иргэн, хараагүй иргэдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг монголын улсын болон гадаадын байгууллага байж болно.
- 11.2 МХҮХ-ны үндсэн гишүүн иргэн нь холбооны гишүүний үнэмлэхтэй, байгууллага нь гэрчилгээтэй байна.

- 11.3 МХҮХ-ны үндсэн гишүүн иргэн нь бүх шатны байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй ба өөрийн нэрийг дэвшүүлж болно.
- 11.4 МХҮХ-ны үндсэн гишүүн нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлнэ.
- 11.5 МХҮХ-ны үндсэн гишүүн нь гишүүнээс саналаараа гарах ба дахин элсэж болно.
- 11.6 МХҮХ-ны үндсэн гишүүн нь үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.
- 11.7 МХҮХ-ны үндсэн гишүүн нь гишүүний татварыг цаг тухайд нь хураалгана.
- 11.8. МХҮХ-ны үндсэн гишүүн нь шилжин суурьшихдаа холбооны гишүүний шилжих хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийлгэнэ.
- 11.9. МХҮХ-ны үндсэн гишүүн байгууллага нь тус холбооноос явуулж буй үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрт хамрагдаж, мэргэжил аргазүйн зөвлөгөө авах эрхтэй.
- 11.10. Хандивлагч гишүүн нь холбоонд санхүүгийн болон бусад хэлбэрээр тусламж дэмжлэг үзүүлдэг Монгол улсын болон гадаадын иргэд, байгууллагууд байна.

Арванхоёр. МХҮХ-ны санхүү

- 12.1 МХҮХ-ны санхүү нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ.Үүнд:
- МХҮХ-ны үндсэн гишүүний татвар жилд иргэн 3000, байгууллага 30000 төгрөг байна
 - Хандивлагч гишүүн ба бусад аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн хандив
 - Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлснээс олсон орлого.
 - МХҮХ-ны дүрмийн зорилгын хүрээнд явуулсан аж ахуйн үйл ажиллагааны орлого
 - Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон төсөл хөтөлбөрүүдээс олсон орлого
- 12.2 МХҮХ-ны санхүүг холбооны дүрмийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.
- 12.3 МХҮХ-ны салбар зөвлөлд харъяалагдаж буй үндсэн гишүүний татварыг тухайн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулна.
- 12.4 МХҮХ-ны санхүү хөрөнгөөр зээлийн хөрөнгийн баталгаа гаргах, төлөхийг хориглоно.
- 12.5 Орлогоос ноогдол ашиг хуваарилахгүй.
- 12.6 МХҮХ-ны гишүүд, ажилтнууд холбооны эд хөрөнгөөс хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 12.7 МХҮХ-ны санхүүгийн орлогоос улс төрийн үйл ажиллагаанд хандив өргөхийг хориглоно.

Арвангурав. МХҮХ-ны татан буулгах үндэслэл

- 13.1 МХҮХ нь зорилгодоо хүрсэн, цаашид ажиллах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд холбооны их хурлаар төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар татан буулгаж болно.
- 13.2 МХҮХ-г татан буулгах тохиолдолд үлдэх хөрөнгийг олон нийтийн эрх ашгийн үүднээс ажиллах ижил төстэй байгууллагад шилжүүлнэ.

Батлав:

МХҮХ-ны ерөнхийлөгч



Гэрэл